



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 7 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 282

Улаанбаатар
хот

Хурдны авто зам ашигласны төлбөрийн хэмжээг тогтоох тухай

Авто замын тухай хуулийн 30-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ НЬ**

1. Улаанбаатар-Хөшигийн хөндийн нисэх онгоцны шинэ буудал чиглэлийн хурдны авто зам ашигласны төлбөрийн хэмжээг хавсралт ёсоор тогтоосугай

2. Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Зам тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгаланд үүрэг болгосугай

Монгол Улсын Ерөнхий сайд

У ХҮРЭЛСҮХ

Зам тээврийн хөгжлийн сайд

Б.ЭНХ-АМГАЛАН

УЛААНБААТАР-ХӨШИГИЙН ХӨНДИЙН ШИНЭ НИСЭХ ОНГОЦНЫ
 БУУДАЛ ЧИГЛЭЛИЙН ХУРДНЫ АВТО ЗАМ АШИГЛАСНЫ
 ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

| Гээврийн хэрэгслийн төрөл | Ангилал | Төлбөрийн хэмжээ (төгрөг) |
|---------------------------|---|---------------------------|
| Суудлын тээврийн хэрэгсэл | "B" ангиллын суудлын автомашин (жолоочоос гадна наймаас илүүгүй хүний суудалтай бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашин) | 2000 |
| | "D1" ангиллын дунд оврын автобус (жолоочоос гадна арван зургаагаас илүүгүй хүний суудалтай "D" ангиллын автомашин) | 10000 |
| | "D" ангиллын том оврын автобус (жолоочоос гадна наймаас илүү хүний суудалтай хүн тээвэрлэхэд зориулсан автомашин) | 20000 |
| | Чиглэлийн тээврийн хэрэгсэл | 5000 |
| Ачааны автомашин | Бүх жин нь 3500 кг-аас илүүгүй "B" ангиллын бага оврын ачааны автомашин | 5000 |
| | Бүх жин нь 7500 кг-аас илүүгүй "C1" ангиллын дунд оврын ачааны автомашин | 10000 |
| | "C" ангиллын том оврын ачааны автомашин ("D" ангилалд хамаарахаас бусад бүх жин нь 3500 кг-аас их автомашин) | 15000 |
| | "CE" ангиллын чиргүүлтэй ачааны автомашин (бүх жин нь 750 кг-аас илүү чиргүүлтэй "C" ангиллын автомашин) | 20000 |
| Бусад | Мотоцикл | 2000 |

**Төлбөр авах цэгээр олон удаагийн нэвтрэх
зөвшөөрөл олгох төлбөрийн хэмжээ**

| Тээврийн хэрэгслийн төрөл | Ангилал | Төлбөрийн хэмжээ /төгрөг/ |
|---------------------------|--|---------------------------|
| Зорчигч тээврийн хэрэгсэл | 12 хүртэл хүний суудалтай | 1000 |
| | 12-24 хүртэл хүний суудалтай | 2000 |
| | 24-өөс дээш хүний суудалтай | 3000 |
| Ачаа тээврийн хэрэгсэл | 2 тэнхлэгтэй 3.5тн хүртэл бодит жинтэй | 2000 |
| | 2 тэнхлэгтэй 3.5-18тн хүртэл бодит жинтэй | 3000 |
| | 3тэнхлэгтэй 18тн хүртэл бодит жинтэй | 4000 |
| | 3тэнхлэгтэй 18-25тн хүртэл бодит жинтэй | 5000 |
| | 4-өөс дээш тэнхлэгтэй 25тн хүртэл бодит жинтэй | 6000 |
| | 4-өөс дээш тэнхлэгтэй 25тн-оос дээш бодит жинтэй | 10000 |
| Бусад | Механизм | 10000 |
| | Мотоцикл | 500 |